



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 4/180


Улаанбаатар хот

### Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах "2IP" уралдаан зохион байгуулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 1.6, 4.14.14, 10.2, Технологийн сангийн журмын 4.4, Технологи дамжуулах журмын 18.2 дахь заалтууд, Захирлын зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд багш, судлаачдын Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах "2IP" уралдааныг 2019 оны 9 дүгээр сард зохион байгуулахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан)-д даалгасгай.
2. Уралдааны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шалгаруулах комиссыг хоёрдугаар хавсралтаар, төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Холбогдох зардлыг батлагдсан төсвийн дагуу гаргахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал (Л.Баяр-Эрдэнэ), эрдэм шинжилгээ хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Мөнхцэнгэл), захиргаа хариуцсан ахлах нягтлан бодогч (Б.Алтантуяа) нарт зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



ШУТИС-ийн Захирлын 2019 оны 15 дугаар сарын 31 өдрийн  
19.0 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ШУТИС-ИЙН БАГШ, СУДЛААЧДЫН  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ /2IP/ ШАЛГАРУУЛАХ  
УДИРДАМЖ**

**ҮНДЭСЛЭЛ:**

ШУТИС-ийн багш, судлаачдын шинжлэх ухаан, технологийн оюуны бүтээлүүдийг шалгаруулж урамшуулах, олон нийтэд таниулан сурталчлах, шинэ технологийг хөгжүүлж улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бүрдүүлэхэд оршино. ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулна.

**ШУТИС-ИЙН ЭРДЭМТДИЙН БҮТЭЭЛ\*-ИЙГ ДАРААХ ҮНДСЭН 3 ТӨРЛӨӨР  
ШАЛГАРУУЛНА. ҮҮНД:**

1. Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл:  
Олон улсын мэргэжлийн сэтгүүлд судалгааны ажлын үр дүнгээ ШУТИС-ийн нэр дээр хэвлүүлсэн тус их сургуулийн багш, судлаачдын бүтээл
2. Шилдэг бүтээл:  
Онол практикийн ач холбогдол бүхий аж үйлдвэрийн оюуны өмч болж хөгжиж болохуйц, шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл
3. Шилдэг технологи:  
Оюуны өмч /Аж үйлдвэрийн өмч/-ийн эрхээр баталгаажсан, үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрэх бүрэн боломжтой шилдэг технологи

**ШАЛГАРУУЛАЛТ:**

- Бүтээлийг шалгаруулах комиссыг ШУТИС-ийн Захирлын тушаалаар баталгаажуулж, 2019 оны 09-р сарын 16-30-ны хооронд шалгаруулна.
- Бүрэлдэхүүн сургууль, судалгааны төв, хүрээлэнгээс Олон улсад хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэлд нэр дэвшүүлэх саналаа ЭШИГ-т, шилдэг бүтээл, шилдэг технологид дэвшүүлэх саналаа Технологи дамжуулалтын төв (ТДТ)-д цахимаар /research@must.edu.mn хаягаар/ 2019 оны 09 дүгээр сарын 02-ноос 09 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэл ирүүлнэ.
- Бүтээл тус бүр зөвхөн нэг ангилалд өрсөлдөнө.
- Эрдэмтэд өөрсдийн дэвшүүлж буй шилдэг бүтээл, шилдэг технологийн танилцуулгыг комиссын хуралд биечлэн хэлэлцүүлж, биет хэлбэрээр үзэсгэлэнд оролцуулж уралдана.

*\*Патентийн тухай хуулийн 3.1.1. "шинэ бүтээл" - байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдэл*

